Бараа материалын эцсийн үлдэгдлийн 93.0 хувийг дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл эзэлж байгаа ба эрүүл мэндийн төвийн оффисын барилга, спорт амралт цогцолборын барилгатай холбоотой байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансны тайлант онд нэмэгдсэн 430,000.0 мянган төгрөг нь спорт амралт цогцолборын барилга дээр нэмэгдсэн байна.

Нийт бараа материалын 93.0 хувийг сумын ОНХС-ын, 6.8 хувийг сумын ЗДТГ-ын, 0.2 хувийг сумын ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй бараа материал эзэлж байна.

**Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	192,711.2	106,631.6	(86,079.6)	6.8
2	ИТХ	2,762.8	3,017.8	255.0	0.2
3	ОНХС	1,026,379.2	1,456,379.2	430,000.0	93.0
	<b>ДҮН</b>	<b>1,221,853.2</b>	<b>1,566,028.6</b>	<b>344,175.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 633,871.1 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 212,605.9 мянган төгрөгийн бараа материал бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж авч, үйл ажиллагаанд 96,181.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Нөөцийн бараа дансны эхний үлдэгдэл 46,500.0 мянган төгрөг нь зураг төсвийн үнэ байсан ба тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зураг төсвийн үнэ 137,900.0 мянган төгрөг нэмэгдсэнээр оны эцэст тус дансны үлдэгдэл 192,200.9 мянган төгрөг болжээ. ы

**3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,323,184.1 мянга, эцсийн үлдэгдэл 4,998,977.2 мянган төгрөг болж, 675,793.1 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	3,246,131.93	3,579,863.66	333,731.7	71.6
Тээврийн хэрэгсэл	351,302.39	453,360.16	102,057.8	9.1
Машин тоног төхөөрөмж	270,033.45	339,789.05	69,755.6	6.8
Тавилга эд хогшил	76,464.55	93,874.55	17,410.0	1.9
Бусад үндсэн хөрөнгө	240,790.38	381,576.38	140,786.0	7.6
Ном	133.40	133.40	-	0.0
Программ хангамж	1,590.00	1,590.00	-	0.0
Бусад биет бус хөрөнгө	136,738.00	148,790.00	12,052.0	3.0
<b>Дүн</b>	<b>4,323,184.1</b>	<b>4,998,977.2</b>	<b>675,793.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 111,995.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 388,741.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 215,425.83 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсан, 40,370.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

**Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	4,311,640.1	4,945,983.7	634,343.6	98.94
2	ИТХ	11,104.0	52,553.5	41,449.5	1.05
3	ХХС	440.0	440.0	-	0.01
	<b>ДҮН</b>	<b>4,323,184.1</b>	<b>4,998,977.2</b>	<b>675,793.1</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.5 Өр төлбөр**

Оны эхэнд 3,617.8 мянган төгрөгийг өглөгтэй байсан ба оны эцэст 2,229.3 мянган төгрөгийн өглөгтэй гарсны 1,206.7 мянган төгрөгийн өглөг нь сумын ЗДТГ-ын ажилчидтай холбоотой өглөг, 1,022.5 мянган төгрөг нь сумын ИТХ-ын байгууллагад төлөх нийгмийн

даатгалын шимтгэлийн өглөг байна.

**Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажилчидтай холбоотой өглөг	Байгууллагад төлөх өглөг
1	ЗДТГ	251.3	1,206.7	1,206.7	-
2	ИТХ	3,366.5	1,022.5		1,022.5
	ДҮН	3,617.8	2,229.3	1,206.7	1,022.5

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,863,913.6 мянга, эцсийн үлдэгдэл 7,707,471.3 мянган төгрөг болж, 2,843,557.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /- /	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	685,579.3	685,579.3	-	8.9
Хуримтлагдсан үр дүн	3,629,218.2	6,472,775.9	2,843,557.7	84.0
Өмнөх үеийн үр дүн	3,126,831.4	3,629,218.2	502,386.7	
Тайлант үеийн үр дүн	502,386.7	2,843,557.7	2,341,171.0	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549,116.2	549,116.2	-	7.1
Дүн	4,863,913.6	7,707,471.3	2,843,557.7	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.7 Орлогын данс**

Шинэжинст сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 827.562.0 мянган төгрөгөөр баталсныг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 126 дугаар тогтоолоор татварын орлогыг 512,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,340,262.0 мянган төгрөгөөр баталжээ.

**Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,340,262.0	2,037,959.7	-697,697.66	152.1
110	Орлогын албан татвар	763,800.0	1,097,655.4	-333,855.36	143.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	763,800.0	1,097,655.4	-333,855.36	143.7
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	617,000.0	891,749.5	-274,749.53	144.5
110002	Үйл ажиллагааны орлого	103,000.0	157,219.4	-54,219.36	152.6
110003	Хөрөнгийн орлого	40,800.0	47,868.5	-7,068.47	117.3
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	818.0	2,182.00	27.3
113	Хөрөнгийн албан татвар	86,640.0	88,158.5	-1,518.51	101.8
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	5,200.0	5,372.2	-172.16	103.3
113002	Бууны албан татвар	1,440.0	1,500.0	-60.00	104.2
113004	Малд ногдуулах албан татвар	80,000.0	81,286.4	-1,286.35	101.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	489,822.0	852,145.8	-362,323.79	174.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	177,878.0	477,109.3	-299,231.27	268.2
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	3,069.1	-1,069.15	153.5
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	150,000.0	451,010.1	-301,010.10	300.7
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	25,878.0	23,030.0	2,847.97	89.0
1181	Газрын төлбөр	291,800.0	366,866.3	-75,066.28	125.7
118101	Газрын төлбөр	290,000.0	329,090.8	-39,090.76	113.5

118102	Дуудлага худалдаа	1,800.0	37,775.5	-35,975.52	2098.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,144.0	8,170.2	11,973.76	40.6
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	14,144.0	7,074.1	7,069.86	50.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6,000.0	1,096.1	4,903.90	18.3

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төлөвлөсөн татварын орлогыг 152.1 хувиар давуулан биелүүлсэн хэдий Өмнөх оны аудитаар хог хаягдлын хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөр, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр зэрэг татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх албан шаардлага өгсөн байхад тайлант онд эдгээр орлогуудын төлөвлөгөө биелээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй тул буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр байгаач Шинэжинст сумын санхүүгийн албаны дарга өндөр настны тэтгэвэрт гарсан, сумын Засаг дарга орон нутгийн сонгуулийн үр дүнгээр солигдсон тул шинээр томилогдсон албан тушаалтнуудад цаашид татварын орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллахыг зөвлөв.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 7,200.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 113,942.6 мянга, ОНХС-д орох өвс тэжээлийн орлогоор 65,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогоор 21,570.0 мянга, сумын ИТХ 6,060.0 мянга, ОНХС-д 84,897.0 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөө биелүүлсэн, харин Хоршоо хөгжүүлэх сан орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

**Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/**

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Шинэжинст	ЗДТГ	7,200.0	21,570.0	14,370.0	300%
2	Шинэжинст	ИТХ	-	6,060.0	6,060.0	0%
3	Шинэжинст	ОНХС	65,000.0	84,897.0	19,897.0	131%
4	Шинэжинст	Хоршоо хөгжүүлэх сан	113,942.6	94,219.1	(19,723.5)	83%
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүн			186,142.6	206,746.1	20,603.5	111.07

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сумын ОНХС-д хандивын орлогоор 300,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснийг бүрэн оруулсан байна.

**3.4.8 Зардлын данс**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 5,359,255.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,267,429.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг

төлөвлөж, Баянхонгор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 5,099,970.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дээрх баталсан анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 126 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, татварын орлогыг 512,700.0 мянга, урьд оны үлдэгдлийг 192,817.9 мянга, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 112,420.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 558,652.3 мянган төгрөгөөр бууруулан, тодотгосон төсвийг 5,359,255.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 13. Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Анхны баталсан 2023.12.19 өдрийн тогтоол	Сумын ИТХ-ын 2024.09.24-ны өдрийн 126 тогтоол	Өөрчлөлт	Дүнд эзлэх хувь
1	татварын орлого	827,562.00	1,340,262.00	512,700.00	25.0
2	Татварын бус орлого /торгуулийн орлого/	15,000.00	15,000.00	0.00	0.3
3	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	598,182.10	39,529.80	-558,652.30	0.7
4	Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	2,907,637.20	3,020,057.20	112,420.00	56.4
5	өөрийн орлого ЗДТГ	7,200.00	7,200.00	0.00	0.1
6	Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан	61,144.10	61,144.10	0.00	1.1
7	Сумын төсвийн урьд оны үлдэгдэл	265,446.20	458,264.10	192,817.90	8.6
8	Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	0.00		0.00	-
9	Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл	52,798.50	52,798.50	0.00	1.0
10	Уул уурхайгаас орох хандив тусламж	300,000.00	300,000.00	0.00	5.6
11	ОНХС Өөрийн орлого	65,000.00	65,000.00	0.00	1.2
	<b>ДҮН</b>	<b>5,099,970.10</b>	<b>5,359,255.70</b>	<b>259,285.60</b>	<b>100.0</b>

Эх сурвалж. Шинэжинст сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 17/05, 2024 оны 01/07 дугаар тогтоол

Шинэжинст сумын төсөвт байгууллагууд оны эцэст зардлын хэмнэлтийн 53,691.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн ба нийт баталсан зардлын 91.8 хувийг гүйцэтгэлээр зарцуулжээ.

Хүснэгт 14. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-т төвлөрүүлсэн
1	ЗДТГ	1,253,635.70	1,242,571.50	11,064.20	99.1	23,364.10
2	ИТХ	225,930.90	216,547.50	9,383.40	95.8	9,383.3
3	ЕБС	164,037.50	154,488.70	9,548.80	94.2	9,548.80
4	Цэцэрлэг	52,376.70	49,673.60	2,703.10	94.8	2,703.10
5	ЭМТ	40,747.50	33,678.80	7,068.70	82.7	7,068.70
6	Соёлын төв	43,527.60	41,904.10	1,623.50	96.3	1,623.40
7	ОНХС	3,465,057.20	3,434,345.80	30,711.40	99.1	0
8	Хоршоо хөгжүүлэх сан	113,942.60	94,219.00	19,723.60	82.7	0
	<b>ДҮН</b>	<b>5,359,255.70</b>	<b>5,267,429.00</b>	<b>91,826.70</b>	<b>98.3</b>	<b>53,691.40</b>

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шинэжинст сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 98,173.8 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 10,466.3 мянга, нийт 108,640.1 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 84,237.8 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 23,880.2 мянга, ИТХ хэмнэлтийн 522.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн орлого, зардал /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	98,173.8	10,466.3	108,640.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,339.5	10,466.3	58,805.8
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,834.3		49,834.3
НИЙТ ЗАРЛАГА	74,293.4	9,944.3	84,237.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,200.4	478.0	39,678.4
Бараа үйлчилгээний бусад зардал	6,980.6		6,980.6
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,112.4	9,466.3	37,578.8
Төсөвт төвлөрүүлсэн	23,880.3	522.0	24,402.3

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Шинэжинст сумын Засаг даргын харьяаны байгууллагууд тавьсан зорилтыг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан ба Төрийн аудитын байгууллагад Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг хүрэх тоо ба чанарын үзүүлэлтээр тайлагнаагүй тул албан шаардлага өгсөн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025.03.06-ны өдөр ирүүлсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Л.Батхуяг, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Н.Баасанжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны баталсан төсөв 5,359,255.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 53,592.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 34,835.2 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шинэжинст сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Төсөвт байгууллагууд тогтмол зардлыг гүйцэтгэлээр олгож, зардлыг 20,098.4 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.
- Бусад зардлуудыг анхан шатны баримтад үндэслэн олгож, хэмнэгдсэн байна.

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан, Шинэжинст сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар тус хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шинэжинст сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2024 онд нийт 12 төрлийн 89 мэдээлэл оруулахаас 86 мэдээллийг хугацаанд нь байршуулан, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Шинэжинст сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд ахлах аудитор Б.Азбаяр, ИТХ болон тусгай сангуудын санхүүгийн тайланд аудитор Д.Цэдэвцэвээн нар завсрын аудитыг 2024 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлийг төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд залруулж арга хэмжээг авч ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Наранцэцэг аудит хийж, албан татварыг орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, дотоод хяналт хариуцлагыг сайжруулах 2 зөвлөмжийг өгсөн байна. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу сумын ЗДТГ-ын даргаар “Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г гаргаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 1/92 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд нийт 409,662.0 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил<sup>1</sup> алдаа, зөрчил илэрсэн, харин тусгай сангуудад илэрсэн зөрчлийг завсрын аудитаар зөрчил арилгасан байна.

Хүснэгт 18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Зөрчлийн ангилал
А	1	2	3	4	6

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Шинэжинст сумын ЗДТГ	Шинэжинст сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор "Шинэжинст суманд нэн шаардлагатай орон тоонд уригдан ирсэн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 46,500.0 мянган төгрөгийн урамшууллыг багш эмч нарт олгохоор баталж 41,850.0 мянган төгрөгийг олгож суутган тооцсон ХАОАТ-ын 2,650.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж 2,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	2,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Санхүүгийн аудит
2	Шинэжинст сумын ЗДТГ	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй хээрийн дадлага сургалт явуулах тухай аймгийн Засаг даргын 2024.05.02-ны өдрийн А/271 дүгээр захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтын зардалд 2024.05.07-д иргэний дансанд 1,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ба анхан шатны баримт байхгүй байна.	1,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Санхүүгийн аудит
3	Шинэжинст сумын ЗДТГ	Сумын Засаг даргын 2024.12.18-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага хувцас бомборын зардалд 4,187.7 мянган төгрөгийг төлсөн байна.	4,187.7	Төлбөрийн акт тогтоосон	Нийцлийн аудит
4	Шинэжинст сумын ЗДТГ	Өмнөх оны санхүүгийн тайлангийн тайланд өглөгөөр бүртгээгүй байхад Дурсамж принт ХХК руу 2024 оны 05 сарын 27 өдөр 2021 онд үйлдвэрлэсэн "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ" 2,645.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.	2,645.0	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
5	Шинэжинст сумын ЗДТГ	2024 оны 04 сарын 08-ны өдөр тээврийн хөлсөнд 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд Э баримтгүй хавсаргаагүй байна.	1,000.0	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
6	Шинэжинст сумын ЗДТГ	Сумын ЗДТГ-ын Ланд-200 автомашины урсгал засварын зардалд 2024.02.16-д иргэнд 17,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна.	17,000.0	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
7	Шинэжинст сумын ЗДТГ	Шинэжинст сумын ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон комисс Баянбулаг омгийн 40 хуц, Залаажинст Эдрэн үүлдрийн 40 ухна хүлээн авсан байхад сумын ЗДТГ-ын хөрөнгөд орлогоор бүртгээгүй байна.	28,000.0	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
8	Шинэжинст сумын ЗДТГ	Тусгай зориулалтын материалаас өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, байгууллагын даргын тушаал шийдвэр гараагүй байхад 36,216.7 мянган төгрөгийн хөрөнгө зарлагдсан байна.	36,216.7	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
9	Шинэжинст сумын ЗДТГ	Тайлан оны санхүүгийн тайланд 129,809.8 мянган төгрөгийн өвс тэжээл орлого авч, 161,936.8 мянган төгрөгийн өвч тэжээлийг зарлагдсан ба өвс тэжээлийн тайланг тусад нь гаргаагүй байна.	161,936.8	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
10	Шинэжинст сумын ЗДТГ	Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Сэгс цагаан богд заставд 10,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Старлинг жөн 3 тоног төхөөрөмж худалдан авч өгсөн ба тухайн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй бөгөөд цаашид тухайн хөрөнгийн засвар үйлчилгээтэй асуудлыг хэн хариуцах талаар тодорхойгүй байна.	10,000.0	Албан шаардлага өгсөн	Санхүүгийн аудит
<b>ДҮН</b>			<b>263,986.2</b>		
1	Шинэжинст сумын ИТХ	Далай ээж" ХХК-ийн хооронд 2024.02.16-ны өдөр байгуулсан "Тавилга, тоног төхөөрөмж худалдан авах" ажлыг гүйцэтгэх гэрээгээр нийлүүлсэн 15,960.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хөрөнгийн нэр төрлөөр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.	15,960.0	Санхүүгийн тайланд залруулсан	Санхүүгийн аудит
2	Шинэжинст сумын ИТХ	Баянхонгор аймгийн Татварын газраас 2025.02.11-ний өдөр ирүүлсэн 44 дүгээр албан бичгээр Шинэжинст сумын ИТХ цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын 1,022.5 мянган төгрөгийн өртэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1,022.5	Санхүүгийн тайланд залруулсан	Санхүүгийн аудит

3	Шинэжинст сумын ИТХ	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 126,099.3 мянга, гүйцэтгэлийг 2,593.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	128,693.2	Санхүүгийн тайланд залруулсан	Санхүүгийн аудит
ДҮН			145,675.8		
НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН			409,662.0		

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,961,627.5 мянган төгрөгийн 2 алдаа<sup>2</sup> илэрснээс аудитын явцад бараа материал, үндсэн хөрөнгө, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- 2023 оны нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 10,455.7 мянган төгрөг, ИТХ-ын төвлөрүүлэх шилжүүлэг 522.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн;
- Санхүүгийн тайланд 1,961,627.5 мянган төгрөгийн устгах бичилтийг хийгээгүй, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Дээрх алдаанууд нь санхүүгийн тайлангийн аудитын Иж бүрэн байх, Толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 436,991.8 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>3</sup> илэрснээс, 409,662.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 27,329.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өглөө.

### 5.1. АЛБАН ШААРДЛАГА

1. Шинэжинст сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх "Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:", 54.5.4 дэх "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 54.4, 54.5 дахь заалтыг хэрэгжүүлэн, тайлант жилийн хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж гарсан үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлага өгөв.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүйгээс Шинэжинст сумын ЗДТГ, ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 409,662.0 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрч, зөрчил давтагдан гарсан байна.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 дахь "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгөв.

## 5.2. ЗӨВЛӨМЖ

1. Сумын ЗДТГ өөрийн орлогоор 7,000.0 мянга, хоршоо хөгжүүлэх сан 113,942.6 мянган төгрөгийг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ төлөвлөгөөг 0.3 хувь, хоршоо хөгжүүлэх сан 82.7 хувиар биелүүлж, баталсан орлогын төлөвлөгөөг 26,901.9 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөж баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-аар орлогыг бодитой төлөвлөж, баталсан өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх

2. Баянхонгор аймгийн Татварын газрын 2025.02.11-ний өдрийн 44 дүгээр албан бичгээр Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний алба цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварт 423.9 мянга, газрын төлбөрт 4.0 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: бүх өр төлбөр" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Баянхонгор аймгийн Татварын газартай тооцоо нийлж, Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний албаны өглөгийг барагдуулах

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг ФАС системд оруулж, биелэлтийг нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн албаны даргад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 10,455.7 мянган төгрөг, ИТХ-ын төвлөрүүлэх шилжүүлэг 522.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн байна.	1	10,977.7			1	10,977.7	1	10,977.7		
Санхүүгийн тайланд устгах бичилтийг хийгээгүй, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.	1	1,950,649.8			1	1,950,649.8	1	1,950,649.8		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,961,627.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>1961627.539</b>	<b>2</b>	<b>1,961,627.5</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Сумын ЗДТГ өөрийн орлогоор 7,000.0 мянга, хоршоо хөгжүүлэх сан 113942.6 мянган төгрөгийг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ төлөвлөгөөг 0.3 хувь, хоршоо хөгжүүлэх сан 82.7 хувиар биелүүлж, баталсан орлогын төлөвлөгөөг 26,901.9 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.	1	26901.9						1	26,901.9
Шинэжинст сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаж ирүүлээгүй байна.	1	0			1	0			
Баянхонгор аймгийн Татварын газрын 2025.02.11-ний өдрийн 44 дүгээр албан бичгээр Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний алба цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварт 423.9 мянга, газрын төлбөрт 4.0 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	427.865						1	427.9
Шинэжинст сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 409.7 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрсэн байна.	1	409,662.0			1	409,662.0			
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>436,991.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>409,662.0</b>	<b>2</b>	<b>27,329.8</b>	

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 268/АОСБ 0238/ТГА-2025/009  
НА-СТА-ТТЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүйгээс Шинэжинст сумын ЗДТГ, ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 409,662.0 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрч, зөрчил давтагдан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 дахь "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь "Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

6425040800

1. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг дарга Л.Батхуяг, санхүүгийн албаны дарга Н.Баасанжаргал нарт даалгав<sup>2, 3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 269/А056 0238/БТТА-2025/009/  
НА-СТА-ТТЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэжинст сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгээр гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх "Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:", 54.5.4 дэх "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

6425040808

1. Төсвийн тухай хуулийн 54.4, 54.5 дахь заалтыг хэрэгжүүлэн, тайлант жилийн хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж гарсан үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг дарга Л.Батхуяг, санхүүгийн албаны дарга Н.Баасанжаргал нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно